Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдааны үеэр
Засаг даргын өгсөн үүрэг даалгавар

2023.01.03

№	Товч агуулга	Хяналт тавих байгууллага
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Байгууллагууд 2023 оны төлөвлөгөөний төслийн боловсруулж, батлуулах	ТЗУХ
2	Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримтлах Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахад төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулах.	НХХ
3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулж, байгууллагын үргүй зардлыг багасгаж, үр дүнг шаардаж ажиллах,	СТСХ
4	Нутгийн захиргааны байгууллагууд ажилтан, албан хаагч, удирдах албан тушаалтнуудын сахилга, хариуцлагыг өндөржүүлж, ажлын цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулж, төрийн албаны тухай хууль тогтоомж, төрийн албаны стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,	ТЗУХ
5	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, албан бичгийг бүх талаас нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх, хариуцлагагүй хандсан удирдлагад хариуцлага тооцож ажиллах,	ТЗУХ
6	Нийтийн эзэмшлийн гудамж, орон сууц, гэр хорооллын гудамж дундах явган хүний зам болон аж ахуй нэгж байгууллагуудын ойр орчмын талбайн цас, мөс цэвэрлэх ажлаа эрчимжүүлж, хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавьж ажиллах.	ТНААХ
7	Мал тэжээвэр амьтны талаар авч хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулах,	ТНААХ
8	Иргэдээс хогны үнэ тарифт өөрчлөлт оруулах саналыг яаралтай авч дуусгах,	ТНААХ
9	2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтыг хангаж эхлэх, он дамжих хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын төлөвлөгөөний саналыг нэгтгэн танилцуулах	СТСХ
10	Малчдад туслах аяны хүрээнд нөөцийн тэжээлийг бэлтгэх, худалдан борлуулах санал болоод шаардлагатай бусад арга хэмжээ-(Эрүүл мэнд, хүнс тэжээл, түлш шатахууны)-г авч хэрэгжүүлэх саналыг авч танилцуулах,	ХХҮХ

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР